

БАТЛАВ.

ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ОЙН ГАЗРЫН ДАРГА

Б.ОЮУНСАНАА

III БҮЛЭГ. ОЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ АРГА ЗҮЙГ ШИНЭЧЛЭН БОЛОВСРУУЛЖ, БАТЛУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

Үндэслэл, шаардлага

Монгол улсын ойн сангийн талбай 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 18,596.1 мянган га байна. Энэ нь Монгол орны нийт нутаг дэвсгэрийн 11.89 хувийг эзэлж байна. Монгол орны ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбай (улсын хэмжээний ойрхог чанар) нь нийт газар нутгийн 8.07 хувийг эзэлж байгаа бөгөөд Монгол улсын ойн сангийн талбайн 83.4 хувийг навч, шилмүүст ой, 16.6 хувийг заган ой эзэлнэ (Монгол улсын ойн сан, 2021).

Энэхүү багахан хувийг эзлэн ургадаг ой нь хөрсийг хамгаалах, бүрдүүлэх, уур амьсгалыг зөөлрүүлэх, зохицуулах, усыг хуримтлуулах, зохицуулах, биологийн олон янз байдлын амьдрах орчин болох, цөлжилтийг бууруулах, түүнээс хамгаалах, хүлэмжийн хийг бууруулах, ард иргэдийг хүнс, модон бүтээгдэхүүнээр хангах, аялал зугаалга хийх, эрүүлжүүлэх, танин мэдэхүй болох, ажлын байр, амьжиргааны эх үүсвэр болох зэрэг нийгэм, эдийн засаг, экологийн өндөр ач холбогдолтой юм.

Сүүлийн жилүүдэд ой нь уур амьсгалын өөрчлөлт болон цаг агаарын дулаарал, хүний сөрөг үр дагавраас шалтгаалан жил бүр хомсдож, доройтсоор байна. 2021 оны ой зохион байгуулалтын ажлын тайлангаас үзэхэд Монгол улсын хэмжээнд ойн хөнөөлт шавж, өвчинд нэрвэгдсэн талбай 102.2 мянган га, мод бэлтгэсэн талбай 130.7 мянган га, шатсан талбай 1,646.2 мянган га байгаа бөгөөд нийт 1,879.1 мянган га талбайн ой түймэр, хөнөөлт шавж, мод бэлтгэлээс болж доройтсон байна. Энэ нь ой зохион байгуулалтын ажлыг эрчимжүүлэх шаардлагатай болохыг харуулж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг Монгол улсын Ерөнхийлөгч “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг зарласан бөгөөд түүнээс хойш ард иргэд, нөхөрлөл, аж ахуйн нэгж байгууллагын мод тарих санаачлаг идэвхжиж, улсын хэмжээнд үр, тарьц, суулгацын нөөц нэмэгдэж, мод тарих, ойжуулалт, ойг нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, санхүүжилтийн хэмжээ нэмэгдэх хандлагатай байна. Үүнтэй уялдан доройтсон ойг нөхөн сэргээх, байгалийн сэргэн ургалтад туслах ажил гүйцэтгэх талбайг сонгох, зураг төсөл боловсруулах шаардлага тулгарч байна.

Мөн ой зохион байгуулалт болон ойн тооллогын ажилд дрон гэх мэт зайнаас тандан судлалын шинэ арга технологи, нэвтэрч байгаа бөгөөд ой зохион байгуулалт хийхэд олон улсад хэрэглэж байгаа арга зүй, аргачлалыг нэвтрүүлэх хэрэгтэй байна.

Иймд ой зохион байгуулалтын ажлын арга зүйг зайлшгүй шинэчлэх шаардлагатай болж байна.

Ажлын зорилго, зорилт

Энэхүү ажил нь ой зохион байгуулалтын ажлын арга зүйг орчин үеийн дэвшилтэт технологи, аргачлалыг нэвтрүүлэн, олон улсын ой зохион байгуулалтын ажлын арга зүй, аргачлалын дагуу шинэчлэн боловсруулах, батлуулах зорилготой бөгөөд дараах зорилтуудыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Одоо хэрэглэж байгаа ой зохион байгуулалтын ажлын арга зүйд дүн шинжилгээ хийж давуу болон сул талуудыг тодорхойлох,
2. Ой зохион байгуулалтын ажилд олон улсад хэрэглэж байгаа арга зүй, аргачлал болон шинэ технологийг судалж, Монгол улсын нөхцөлд хэрэглэж болох эсэхийг тодорхойлох,
3. Ойн зохион байгуулалтын ажлын арга зүйн төслийг шинэчлэн боловсруулах,
4. Шинэчлэн боловсруулсан ой зохион байгуулалтын ажлын арга зүйн төслийг Ойн нөөцийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлж, батлуулах зэрэг болно.

Хийгдэх ажлууд

Одоо хэрэглэж байгаа ой зохион байгуулалтын ажлын арга зүйд дүн шинжилгээ хийж давуу болон сул талуудыг тодорхойлох зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Одоо хэрэглэж байгаа ой зохион байгуулалтын ажлын арга зүйд дүн шинжилгээ хийх,
- Ойн мэргэжлийн байгууллагууд, судлаачид, их дээд сургуулийн багш нарыг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгуулж, одоо хэрэглэж байгаа ой зохион байгуулалтын арга зүйн сул болон давуу талуудыг тодорхойлох,
- Ой зохион байгуулалтын арга зүйг хэрхэн шинэчлэх талаар санал боловсруулах,

Ой зохион байгуулалтын ажилд олон улсад хэрэглэж байгаа арга зүй, аргачлал болон шинэ технологийг судалж, Монгол улсын нөхцөлд хэрэглэж болох эсэхийг тодорхойлох зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Ой зохион байгуулалтын ажилд олон улсад хэрэглэж байгаа арга зүй, аргачлалыг судалж тогтоох,
- Ой зохион байгуулалтын ажилд нэвтэрч байгаа шинэ технологийг судалж, тогтоох,
- Олон улсад хэрэглэж буй арга зүй, аргачлал болон шинэ технологиудыг Монгол улсад хэрэглэж болох эсэхийг тогтоох,

Ойн зохион байгуулалтын ажлын арга зүйн төслийг шинэчлэн боловсруулах зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Ойн зохион байгуулалтын ажлын арга зүйн төслийг шинэчлэн боловсруулах,
- Арга зүйн төслийг холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлэх, саналыг тусгах,
- Шинэ арга зүйг хэрэглэхэд холбогдох хууль эрх зүйн актууд болон бусад бичиг баримтуудад өөрчлөлт орох эсэхийг тогтоох, өөрчлөлт орох бол төслийг боловсруулах,

Шинэчлэн боловсруулсан ой зохион байгуулалтын ажлын арга зүйн төслийг батлуулах зорилтын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Ой зохион байгуулалтын ажлын арга зүйг батлуулах бэлтгэлийг хангах,

- Ойн мэргэжлийн байгууллагуудад сургалт зохион байгуулах

Ажлыг гүйцэтгэх хугацаа, үе шат

Ажлыг тендерийн үе шатны ажлын хуваарь, тайлан өгөх хуваарийн дагуу гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд гүйцэтгэнэ.

Хүлээгдэж буй үр дүн

Тус судалгааны ажлыг хийж гүйцэтгэснээр дараах үр дүнд хүрнэ. Үүнд:

1. Одоо хэрэглэж байгаа ой зохион байгуулалтын ажлын арга зүйд дүн шинжилгээ хийж давуу болон сул талуудыг тодорхойлсон байна.
2. Ой зохион байгуулалтын ажилд олон улсад хэрэглэж байгаа арга зүй, аргачлал болон шинэ технологийг судалж, Монгол улсын нөхцөлд хэрэглэж болох эсэхийг тодорхойлж гаргасан байна.
3. Ойн зохион байгуулалтын ажлын арга зүйн төслийг шинэчлэн боловсруулна.
4. Шинэчлэн боловсруулсан ой зохион байгуулалтын ажлын арга зүйн төслийг холбогдох байгууллагуудаар хэлэлцүүлж, батлуулсан байна.

ЗГХА Ойн газар